



ДУАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

**Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын үр дүнд
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан
ДУАГ-САБ/2017-01-ГА**



*Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт
хийгдээгүйгээс зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу
хийгдэхгүй байна.*

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	<i>Товчилсон үгс</i>	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....</i> <i>Ерөнхий мэдээлэл.....</i>	4-5 5-6
Дарга, Тэргүүлэх аудитор: Т.ОЮУНЧИМЭГ	<i>БҮЛЭГ 1. Зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь төвлөрүүлээгүй байна.</i>	
	<i>1.1.Нийт авлагын 42.3 хувь нь 7 сараас дээш хугацаагаар хэтэрсэн байна.....</i>	7-8
Аудитын менежер: Х.НАРАНЦАЦРАЛ	<i>1.2. Зарим сумд гэрээний хугацаандаа эргэн төлөгдөөгүй авлагын үлдэгдлээс алданги тооцож бүртгээгүй байна</i>	8-10
Ахлах аудитор: Т.БАТСАЙХАН	<i>БҮЛЭГ 2. Зарим төсөл хэрэгжүүлэгч сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байгаа нь үр ашгийг бууруулж байна.</i>	
Аудитор: Б.ГАНТУЯА Ж.УГТАХБАЯР С.ЖАЛБАА	<i>2.1. Төсөл сонгон шалгаруулахдаа чанаргүй, эдийн засгийн тооцоо, судалгаа муутай төслийг сонгон шалгаруулсан байна.</i>	10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593113 дугаарын угааар харилцана уу.	<i>2.2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт үр ашиг багатай байна.</i>	11
	<i>2.3. Төсөл хэрэгжүүлэгч зээлийг үр дүнгүй, зориулалт бусаар зарцуулж байгаа нь сангийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.</i>	11-13
Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn	<i>БҮЛЭГ 3. Хяналтын орон тооны бус зөвлөл сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна</i>	
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 210 тоот	<i>3.1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөнд тавих хяналт хангалтгүй байна..</i>	13
	<i>3.2 Мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.</i>	14
2017 оны 7 дугаар сар	<i>Дүгнэлт</i>	15
	<i>Зөвлөмж</i>	15
	<i>Санал тайлбар.....</i>	16
	<i>Тайлан баталгаажуулсан тушаал.....</i>	17-23
	<i>Хавсралт</i>	24-26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Сангийн эх үүсвэрийг журмын дагуу бүрдүүлсэн эсэх;
- Сангийн хөрөнгийн зарцуулалт үр ашигтай эсэх;
- Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур эх сурвалж болгон ашиглалаа.

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Хөдөлмөрийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/28 дугаар тушаал;
- Холбогдох бусад, хууль журам.

Хамарсан хүрээ

Аудитад ХХААГ, 15 сумын Сум хөгжүүлэх сангийн тайлан, мэдээ, төсөл хэрэгжүүлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийг судалгааны түвшинд хамруулсан.

Аудитын явцад Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай, Адаацаг, Сайнцагаан сумдын Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, захирамж, тогтоол шийдвэр, зээлийн гэрээ, зээлийн гэрээний хэрэгжилтийг тооцсон акт баримт, хурлын

тэмдэглэл, санхүүгийн тайлан, ажлын баримтуудтай танилцаж, зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийг түүвэрлэн давтан тооцоолол хийлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын олон улсын стандарт, АДБОУС, Гүйцэтгэлийн аудитын журам, Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмжийг мөрдөж, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тулган баталгаажуулах, давтан тооцоолол хийх, ажиглалт хийх, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэн, ажлын баримтуудыг бэлтгэн, нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын явцад аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, сумдын Засаг дарга, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, төсөл шалгаруулах болон хяналтын орон тооны бус зөвлөлийн зарим төлөөлөл, төсөл хэрэгжүүлэгч иргэдтэй уулзан зээлийн эргэн төлөлт, зээлийн үр дүн, үйлдэрлэл үйлчилгээ эрхлэлтийн талаар судалгаа авч ажиллаа.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, багийн бүрэлдэхүүн

Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 07 дугаар сарын 31-нийг хүртэл хугацаанд тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцарал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, санхүүгийн аудитын багийн ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Б.Гантуяа, Ж.Угтахбаяр, С.Жалбаа нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Аудитаар нийт 924.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 516.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 94.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, 313.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөв. Аудитын явцад 12.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг нөхөн төлүүлж, зөрчлийг арилгууллаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Анх 1996 оны 258 дугаар тогтоолоор сумдад жижиг, дунд үйлдвэр байгуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, өргөтгөхөд нь дэмжлэг үзүүлэхэд зориулан төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр санхүүжилт олгон, Сум хөгжүүлэх санг байгуулжээ.

Дээрх тогтоолыг 2001 онд ЗГ-ын 157 дугаар тогтоол, 2011 онд 134 дүгээр тогтоолоор тус тус хүчингүй болгож, 2016 онд 153 дугаар тогтоолоор журмыг шинэчлэн баталсан байна.

Сум хөгжүүлэх санд 2011-2013 онд нийт 3,000.0 сая төгрөг хуваарилан Төрийн сангаар дамжуулан олгож, 2012 онд санхүүжилт олгоогүй байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2016 онд 134 төсөл хэрэгжүүлэгчдэд 877.0 сая төгрөгийн, 2017 оны 1 дүгээр улиралд 43 төсөл хэрэгжүүлэгчдэд 313.5 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна. 2016 онд 1,147.8 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдсэн ба

эргэн төлөлт болон нэмж олгосон зээлийг судлаж үзэхэд дараахь сумд зээлийг олгосон байна. /Хүснэгт №1/

Үүнийг хүснэгтээр харуулбал:

/Сая төгрөгөөр/

№	Сумдын нэр	2016 он		
		эргэн төлөлт	олгосон зээл	үлдэгдэл
1	Говь-Угтаал	43.6	0.8	42.8
2	Баянжаргалан	41.2	5.8	35.4
3	Өлзийт	61.5	1.4	60.2
4	Дэлгэрхангай	35.8	0.8	35.0
	Дүн	182.1	8.7	173.4

Дээрх сумд зээлийн эргэн төлөлтөөс 182.1 сая төгрөгийг төвлөрүүлж, шинээр 8.7 сая төгрөгийн зээл олголтыг хийсэн байна. СХС-ийн авлага нь 2016 оны эхэнд 3,241.7 сая төгрөг, жилийн эцэст 3,083.3 сая төгрөг буюу өмнөх оноос 158.4 сая төгрөгөөр буурсан байна. Дээрх авлага нь ТЕЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 50.4 хувийг эзэлж байна.

Бүлэг 1

Зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь төвлөрүүлээгүй байна.

1.1. Нийт авлагын 42.3 хувь нь 7 сараас дээш хугацаагаар хэтэрсэн байна

Аймгийн хэмжээгээр Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгө 2016 оны эхэнд 475.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлангийн хугацаанд 1,148.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 876.0 сая төгрөгийг зарцуулан, жилийн эцэст 748.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацааны орлогын 92.9 хувь буюу 1,067.9 сая төгрөг нь зээлийн эргэн төлөлт, 5.6 хувь буюу 63.2 сая төгрөг нь зээлийн хүүгээс, 1.5 хувь буюу 17.7 сая төгрөг нь алданги болон бусад орлогоос /залруулсан гүйлгээ/ орсон байна. /хавсралт №1/

Сум хөгжүүлэх сангийн нийт авлага 2016 оны жилийн эцэст нийт 3,083.3 сая, 2017 оны 5 сарын дүнгээр 3,057.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитад хамрагдсан сумдын хугацаа хэтэрсэн авлагыг авлагын нийт дүнд эзлэх хувиар харьцуулахад хамгийн их нь Өлзийт сум 79.9 хувь, Адаацаг сум хамгийн бага буюу 13.8 хувь байна.

Авлагын хувийг графикаар харуулбал:

/сая төгрөг/



Сумдаас Говь-Угтаал сумын хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2016 оны эхний үлдэгдлээс 5.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Говь-Угтаал сум хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бууруулахын тулд 2016, 2017 онд огт зээл олгоогүй, мөн малчдын орлогын гол эх үүсвэр болох ноос, ноолуур борлуулах үеэр авлага барагдуулах ажил зохион байгуулсантай холбоотой байна.

Гурвансайхан сум гэрээний хугацаандаа төлөгдөөгүй нийт 63.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй 19 зээлдэгчид мэдэгдлийг 2017 оны 1 дүгээр сард хүргүүлсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Сумдын зээлийн хүүгийн тооцооллыг харьцуулж үзэхэд Сайнцагаан сум эргэн төлөлт хийгдээгүй тохиолдолд зээлийн хүүг төлөгдөөгүй үлдэгдлээс тооцон, зээл төлөгдсөний дараа сараас төлөгдөх зээлийн хүүгийн төлбөрийг бууруулан тооцсон, харин бусад сумд зээл хуваарьтай хугацаандаа төлөгдсөн эсэхээс үл хамааран төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулсан

гэрээний хавсралт дахь эргэн төлөлтийн хуваарийн дагуу хүүг бууруулан тооцож бүртгэсэн байна.


Цаашид зээлийн хүүг зээлдэгчтэй байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу тооцон бүртгэж, хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд журмын дагуу алданги тооцох нь зүйтэй.

Аудитын дүнгээс үзэхэд Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг гэрээний хугацаанд эргэн төвлөрүүлж жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах эх үүсвэрийг цаг тухай бүрт нь бүрдүүлж чадаагүй, зээлийн эргэн төлөлт удаашралтай байна.

Аудитаар гэрээний хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг нөхөн төлүүлж хохирлыг барагдуулахаар 280.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулахаар 94.6 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Сумдын Сум хөгжүүлэх сангийн гэрээний эргэн төлөгдөх хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн авлагын насжилтыг харьцуулж үзэхэд нийт авлагын 42.3 хувь нь 7 сараас дээш хугацаагаар хэтэрсэн байна. /Хавсралт №3/

Авлагын насжилтыг диаграмаар харьцуулан харуулбал:



Аудитад хамрагдсан сумдын Сум хөгжүүлэх санд гэрээний хугацаандаа эргэн төлөгдөөгүй нийт 629.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг хугацаанд нь төвлөрүүлсэн бол дунджаар 15.0-20.0 сая төгрөгийн 31-42 төслийг эхлүүлэх буюу үйл ажиллагааг өргөжүүлэх боломжтой байсан байна.

1.2 Зарим сумд гэрээний хугацаандаа эргэн төлөгдөөгүй авлагын үлдэгдлээс алданги тооцож бүртгээгүй байна.

Аудитаар сумдын Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүү, алдангийн тооцоолол, бүртгэлийг харьцуулж үзэхэд 2016 онд Дэлгэрцогт, Дэрэн, Баянжаргалан, Өндөршил, Өлзийт, Луус, Дэрэн, Цагаандэлгэр, Сайхан-Овоо сумд огт алданги тооцоогүй, бусад сумд 0.01-13.0 сая төгрөгийн алданги тооцож авсан байна.

Эрдэнэдалай, Адаацаг, Говь-Угтаал, Сайнцагаан сумд алдангийг тооцоолохдоо төлөгдөөгүй зээлийн үлдэгдлээс гэрээнд заасны дагуу хугацаа хэтэрсэн хоногоор тооцоолсон. Харин Говь-Угтаал, Гурвансайхан сумд эргэн төлөлт хийгдээгүй нийт хугацааны эхний сард нэг удаа тооцсон нь алдангийг дутуу тооцох эрсдэлийг бий болгосон байна. Тооцооллыг харьцуулж хүснэгтээр харуулав. /Хүснэгт №2/

Алдангийн тооцооллын харьцуулсан жишээ

сар	өдөр	Говь-Угтаал			Гурвансайхан		
		Гэрээний эргэн төлөгдөх хуваарь	төлсөн зээл	тооцсон алданги	Гэрээний эргэн төлөгдөх хуваарь	төлсөн зээл	тооцсон алданги
1	31	461,600		2,387			
2	28			2,156	300,000		1,323
3	31			2,387			
4	30			2,310			
5	31			2,387		300,000	
6	30			2,310			
7	31			2,387	300,000		1,323
8	31			2,387			
9	30			2,310			
10	31		461,600	1,540			
11	30						
12	31						
дүн		461,600	461,600	22,561	600,000	300,000	2,646

Алдангийг дутуу тооцсон буюу огт тооцоогүй, төсөл хэрэгжүүлэгч нарт танилцуулж үр дагаврыг нь ойлгуулж ажиллаагүйгээс зээлийг эргэн төлүүлэх хөшүүрэг болж чадаагүй, зөвхөн нягтлан бодогчийн тооцоолол болж үлдсэн байна.

Иймд зээлийн хүүг гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу тооцон бүртгэж, зээл төлөгдөөгүй тохиолдолд зээлийн хүүгийн тооцооллыг зогсоож, алдангийг тооцож бүртгэн барагдуулах нь зүйтэй.

Сумд төсөл хэрэгжүүлэгчидтэй байгуулсан гэрээний хавсралтын дагуу зээл, зээлийн хүүг авлагаар бүртгэж тайлагнасан бол Цагаандэлгэр сум 2017 оны 5 сарын байдлаар 5.6 сая төгрөгийн зээлийн хүүг санхүүгийн тайланд авлагаар тооцож бүртгээгүй, зөвхөн зээлийн эргэн төлөлтийг НББ-ийн программд авлагаар тусгаж, зээлийн хүүг харилцах дансанд орсон тухай бүрт нь орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэл тайланд тусгасан, алданги огт тооцоогүй байна. Харин ЖДҮ хариуцсан мэргэжилтэн зээлийн хүүг төлөгдөөгүй үлдэгдлээс гэрээнд заасан хувиар тооцож хүн тус бүр дээр карт нээж хөтөлжээ.

Цагаандэлгэр сум зээлийн хүүгийн авлагыг аккруэль сууриар бүртгээгүйгээс санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, холбогдох албан тушаалтнуудын ажлын уялдаа хангалтгүйгээс бүртгэлийн тооцоонд зөрүү үүсэх эрсдэлийг дагуулж байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.7 /Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд тодорхой тусгана/-д заасны дагуу алдангийг тооцсон бол 2016 онд Цагаандэлгэр сум 26.5 сая төгрөг, Говь-Угтаал сум 16.6 сая төгрөг, Гурвансайхан сум 45.6 сая төгрөг, Өлзийт сум 38.7 сая төгрөг, 2017 онд Цагаандэлгэр сум 3.3 сая төгрөг, Говь-Угтаал сум 1.4 сая төгрөг, Гурвансайхан сум 2.9 сая төгрөгийн алданги, нийт 134.7 сая төгрөгийн алдангийг тооцож авах боломжтой байжээ.

Аудитаар алдангийг үнэн зөв тооцох, гэрээний хугацаандаа зээлээ эргэн төлөөгүйгээс үүсэн алдангийн үр дагаврыг төсөл хэрэгжүүлэгчдэд ойлгуулж хамтарч ажиллах талаар зөвлөмж өглөө.

Төсөл хэрэгжүүлэгч нар зээл, зээлийн хүүг гэрээний хугацаанд нь эргэн төлөхгүй байгаа нь нэг талаас Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэр цаг тухайдаа бүрдэж дараагийн төслийг санхүүжүүлэх боломжийг алдагдуулах, нөгөө талаас зээлийн эргэн төлөлт хуримтлагдан, зээлдэгчдэд зээлийн дарамт учруулахыг аль аль талдаа ойлгож хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, төлбөр тооцоог яаралтай барагдуулах шаардлагатай байна.

Мөн зээлийн хүүг үнэн зөв тооцох, ажил хариуцсан албан тушаалтнуудын ажлын уялдааг сайжруулах, бүртгэл тайланг стандартын дагуу гаргах шаардлагатай.

Бүлэг 2 **Зарим төсөл хэрэгжүүлэгч сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байгаа нь үр ашгийг бууруулж байна.**

2.1. Төсөл сонгон шалгаруулахдаа чанаргүй, эдийн засгийн тооцоо, судалгаа муутай төслийг сонгон шалгаруулсан байна.

Аудитад хамрагдсан 7 сумын хувьд сум хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тэргүүлэх чиглэлээ батлан, төсөл сонгон шалгаруулах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг холбогдох журмын дагуу байгуулж ажиллажээ.

Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл нь зээл хүсэгчийн ирүүлсэн төсөлд эдийн засгийн тооцоо, судалгаа хийж, учирч болзошгүй эрсдэлийг тооцоолж, зах зээлийг бүрэн судлаагүйгээс төдийлөн сайн төслийг сонгон шалгаруулж чадахгүй байна.


Энэ нь сумын хөгжлийн үндсэн чиглэл, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн ямар салбарт эрэлт хэрэгцээ их байгааг нарийн судлаагүйтэй холбоотой байна.

Мөн төлбөрийн чадваргүй иргэдийг төсөлд сонгон шалгаруулж байгаа нь төсөл хэрэгжихгүй байх, олгосон зээлийг зориулалт бусаар зарцуулах, хэрэглээний зээл байдлаар ашиглах явдал их байна.

Ёёё ä ø ñëëä ñí äí ø äëäðòòëäòäàà төсөл хэрэгжүүлэхээр ирүүлсэн төслийн хэрэгцээ шаардлага, нийт төсөвт өртгийн эдийн засгийн үндэслэлийг сайтар судалж, хэрэгжих боломжтой, жòðàì ä çààñàí ø äëäòòð үзүүлэлтийг бүрэн хангасан төслийг санхүүжүүлэх шаардлагатай байна.

2.2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт үр ашиг багатай байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1.8-д /Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна/ гэж заажээ. Уг заалтын хүрээнд Сум хөгжүүлэх сангийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургалт, хяналтад тодорхой хэмжээгээр зарцуулсан байна. Үүнийг диаграммаар харуулбал:



2016 онд нийт зардлын 16 хувь буюу 4.1 сая төгрөгийг сургалтын зардалд, 67 хувь буюу 17.3 сая төгрөгийг санхүүгийн программ болон бусад зардалд, үлдсэн 17 хувь буюу 4.4 сая төгрөгийг хяналтанд, 2017 оны эхний 5 сарын байдлаар нийт зардлын 83 хувь буюу 2.5 сая төгрөгийг сургалтанд зарцуулж, үлдсэн хувийг хяналтанд тус тус зарцуулжээ. /Хавсралт №2-оор харуулав/

Сум бүр Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүртгэлийг сайжруулах зорилгоор 0.7 сая төгрөгийн үнэ бүхий санхүүгийн программыг худалдан авсан ч тус программыг бүрэн ашиглаагүй байгаа нь төдийлөн үр дүнгээ өгөөгүй байна.

Мөн 2016 онд хийсэн нийцлийн болон санхүүгийн аудитаар сангаас олгосон зээлийн хүүгийн орлогыг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрч, зөрчлийг арилгуулахаар 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.3. Төсөл хэрэгжүүлэгч зээлийг үр дүнгүй, зориулалт бусаар зарцуулж байгаа нь сангийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.

Сум хөгжүүлэх сангаас 2016 онд нийт 146 төсөл, 2017 оны эхний 5 сарын байдлаар 46 төсөл дэмжигдэн зээл олгогдсон байна. Үүнийг диаграммаар харьцуулан харуулбал:



Үүнээс харахад Сайнцагаан сум хамгийн олон буюу 55 төсөл, Адаацаг сум 33 төсөл хэрэгжүүлсэн. Харин Говь-Угтаал, Баянжаргалан, Дэлгэрхангай сумд огт төсөл шалгаруулаагүй байна.

2016 он, 2017 оны эхний хагас жилд дэмжигдсэн төсөлд нийт 1,345.2 сая төгрөгийн зээлийг олгосон ба зээлийн дийлэнх хувь буюу 37 хувийг хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн 71 төсөлд, 15 хувийг хүнсний

үйлдвэрлэлийн чиглэлийн 28 төсөлд, 13 хувийг мал аж ахуйн чиглэлийн 24 төсөлд, 15 хувийг хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийн 28 төсөлд, 13 хувийг мал аж ахуйн чиглэлийн 24 төсөлд тус тус олгосон байна. Хэрэгжиж байгаа төслийг үйл ажиллагааны чиглэлээр харуулбал:



Аудитад хамрагдсан 7 сумын хувьд төслийг сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл сонгон шалгаруулж, дэмжигдсэн төслийг сумын Засаг даргын захирамжаар санхүүжүүлсэн байна.

Дээрх зөвлөл нь төсөл хэрэгжүүлэгчийг оновчтой сонгон шалгаруулаагүй, төслийг сонгон шалгаруулахдаа сум орон нутгийнхаа онцлогийг харгалзан үзэж, нэн тэргүүнд шаардлагатай үндсэн чиглэлийг санхүүжүүлэхээр сонгоогүй, нэг чиглэлийн төсөлд давхар зээл олгосон, иргэдээс

ирүүлсэн төслийн зах зээлийн эрэлт хэрэгцээг судлаагүй, тухайн орон нутагт оршин суудаггүй иргэнд зээл өгдөг зэргээс СХС-ийн зорилго алдагджээ.

- Аудитаар зээлийг зориулалт бусаар зарцуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нэр бүхий 9 зээлдэгч нарын нийт 140.0 сая төгрөгийн төслийн эх үүсвэрийг буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоон холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүллээ. Тухайлбал: Адаацаг сумын төсөл хэрэгжүүлэгч А.Цолмонбаатар мал эмнэлгийн чиглэлээр 35.0 сая төгрөг;
- Өлзийт сумын төсөл хэрэгжүүлэгч М.Идэрхүү зөөврийн орон сууц барих зориулалтаар 14.0 сая төгрөг;
- Эрдэнэдалай сумын төсөл хэрэгжүүлэгч “Тэнгэрлэг хачу” хоршоо эсгий үйлдвэрлэлийн чиглэлээр 30.0 сая төгрөг, “Эрч хүч” эв нэгдэл хоршоо хүнсний ногооны чиглэлээр 15.0 сая, Бат-Эрдэнэ 10.0 сая төгрөг;
- Гурвансайхан сумын төсөл хэрэгжүүлэгч Р.Сүхбаатар фото студийн чиглэлээр 7.0 сая төгрөг, Э.Отгонбаатар компьютер засварын чиглэлээр 5.0 сая, П.Жигжид шингэн түлшний чиглэлээр 18.0 сая төгрөг;
- Цагаандэлгэр сумын төсөл хэрэгжүүлэгч Х.Оюун-Амгалан бичиг хэргийн худалдааны чиглэлээр 6.0 сая төгрөг.

Дээрх зөрчлүүд нь СХС-ийн журмын 1.2-д “Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна”, мөн зээлийн гэрээнд “Сангаас олгосон зээлийг дээрх журамд заасан зориулалтаар зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Мөн Сайнцагаан сумын үйл ажиллагаа нь жигдрээгүй “Тэвш таван эрдэнэ” ХХК, иргэн О.Өлзийдүүрэн, Б.Лхагвасүрэн нарын нийт 70.0 сая төгрөгийн 3 төсөлд үйл ажиллагааг эрчимжүүлэх хугацаатай зөвлөмж хүргүүллээ.

Харин зээлээ зориулалтын дагуу зарцуулж, төслөө амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлж, орон нутгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байна. Тухайлбал:

- *Эрдэнэдалай сумын төсөл хэрэгжүүлэгч “Ni ä ädëëëäi ò ” ХХК цэвэр усны чиглэлээр, Б.Буджав блок үйлдвэрлэлийн чиглэлээр,*
- *Адаацаг сумын төсөл хэрэгжүүлэгч Г.Цогнэмэх блок, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр төслөө амжилттай хэрэгжүүлж байна.*

Бүлэг 3

Хяналтын орон тооны бус зөвлөл сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна

3.1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөнд тавих хяналт хангалтгүй байна.

Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай, Адаацаг, Сайнцагаан сумд журмын дагуу хяналтын орон тооны бус зөвлөлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулсан байна. Эрдэнэдалай сумаас бусад сумдын орон тооны бус зөвлөл нь сангийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аудитын явцад сумдаас сангийн хөрөнгийн үйл ажиллагаанд хяналт хийсэн ажлын тайлан болон холбогдох баримт материалыг шаардсан боловч гаргаж өгөөгүй нь хяналт хийгдээгүй гэж дүгнэхэд хүрч байна.

Хяналтын орон тооны бус зөвлөл нь журмын дагуу ажиллахгүй байгаа нь сангаас олгосон зээлийн эргэн төлөлт, зарцуулалтын талаар дээрх бүлгүүдэд дурдагдсан зөрчлүүд үүсэх гол нөхцөл болж байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах хяналт тавих журмын 6.2 /Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй буюу энэ журамд заасныг зөрчиж төсөл сонгон шалгаруулах, төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол тухайн сумын Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ/-д заасны дагуу үүргээ биелүүлээгүй албан тушаалнуудад хариуцлага тооцуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Цаашид сангийн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, холбогдох журмыг хэрэгжүүлээгүй ажлын хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлагын арга хэмжээг авч ажиллах, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Харин Эрдэнэдалай сум төслийг сонгон шалгаруулахдаа нийт төсөл хэрэгжүүлэгчдийн дунд төслийн танилцуулга хийлгэн хамгаалуулж ил тод шалгаруулсан, мөн төсөл хэрэгжүүлэгчид хоршин ажиллаж байгаа нь бие биенээсээ суралцах, үйл ажиллагаа өргөжих давуу талууд байна. Сангийн үйл ажиллагаанд хяналт хийж дүнг сумын ИТХ-д танилцуулсан, ИТХ-аас хяналтын орон тооны зөвлөлд зөвлөмж хүргүүлж ажилласан зэрэг нь бусад суманд туршлага болохуйц сайн ажлууд хийгджээ.

Сумын Засаг дарга хугацаа хэтэрсэн зээлтэй иргэд, ААНБ-уудын зээлийн өрийг барагдуулахаар 2016 оны 09 сарын 08-ны өдрийн 77, 78, 80, 82, 88, 89, 111 дүгээр нийт 7 нэхэмжлэлийг гаргаж аймгийн шүүхийн байгууллагад хүргүүлсэн боловч Засаг даргын орлогч нэхэмжлэлийг буцаан татаж нэхэмжлэлийг хүчингүй болгож зээлийг барагдуулах талаар авсан арга хэмжээг үр дүнгүй болгосон байна.

3.2. Мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын талаарх Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад Цагаандэлгэр, Сайнцагаан, Говь-Угтаал, Өлзийт, Адаацаг, Эрдэнэдалай, Гурвансайхан сумд сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг танилцуулсан зурагт хуудас, мэдээ судалгааг гаргаж мэдээллийн самбартаа байршуулсан боловч олон нийтийн хурал цуглаан дээр сантай холбоотой журам, зааврын талаар мэдээ мэдээлэл хийх, сурталчилан таниулах арга хэмжээ авсан материал байхгүй нийтлэг зөрчлүүд байна.

Сум хөгжүүлэх сангийн мэдээ тайланг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх бие даасан цэст нээж өгөөгүй бөгөөд тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд сумын бүх сангуудын тайлантай нэгтгэн гаргаж байршуулсан нь сангийн гүйцэтгэлийг харах боломжгүй байна.

Харин сангаас зээл олгосон захирамж болон зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдон гарсан зардлын тушаал шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд байршуулж болохоор байна.

Цаашид Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу тухайн жилийн сангийн санхүүгийн үйл ажиллагааг цахим хуудас, мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулан нийтэд мэдээлж ажиллах хэрэгтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.1.4./ *сангаас олгосон зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах/-д заасны дагуу нэгдсэн сангийн мэдээллийг Монгол банкинд байршуулах ажиллагаа хэрэгжих шатанд явагдаж байна.*

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

1. Сумдын зээл хугацаандаа эргэн төлөгдөөгүй 13.8-79.9 хувь нь хугацаа хэтэрсэн, зарим сумд алданги тооцож аваагүй байна.
2. Зарим төслийг сонгон шалгаруулахдаа тооцоо, судалгаанд үндэслээгүй байна.
3. Төсөл хэрэгжүүлэгч зээлийг үр дүнгүй, зориулалт бусаар зарцуулж байгаа нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
4. Хяналтын орон тооны бус зөвлөл сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-д:

1. Сангийн хөрөнгийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэн, сангийн төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах;

Аймгийн Засаг даргад:

2. Сангаас олгосон зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах бэлтгэл ажлыг хангах;

Сумдын Засаг дарга нарт:

1. СХС-ийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах ажлыг нэн яаралтай зохион байгуулж, сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх;
2. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд зээлдэгчтэй байгуулсан гэрээний дагуу алданги тооцож нөхөн төлүүлэх;
3. Төсөл сонгон шалгаруулах ажлыг оновчтой зохион байгуулж, тус үйл ажиллагаанд сумын иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах;
4. Зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг тухай бүр зохион байгуулж, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулах;

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг
Утас/Факс: 70-59-25-86


2017.07.26 № 0/187
танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Сум хөгжүүлэх сангийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийсэн, тайлангийн төсөлтэй танилцлаа.

Санал тайлбар байхгүй.

ДАРГА  Б.МӨНХЖАРГАЛ



Т.Батайхану

- 1. Тайлангийн төсөл оруулж, тайлан зурвасом зөвлөлийн үүрэгээр оруулах 125700239. Бэлтгэ*
- 2. Төгсөлийн зохимж оруулж*

Р 10/26

Тайлан баталгаажуулсан тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 31 өдөр

Дугаар АМ6

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУАГ-САБ/2017/01-ГА/ -г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Хүнс хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар аймаг, суманд илэрсэн зөрчлүүдийг арилгаж, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 10 сарын 20-ны дотор Аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга /С.Сүхбаатар/, Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Мөнхжаргал/ нарт зөвлөсүгэй.
5. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг Аудитын менежер /Х.Наранцацрал/, Санхүүгийн аудитын багийн ахлах аудитор /Т.Батсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ОЮУНЧИМЭГ



D:\office\Alban bichig\A4\сум хөгжүүлэх-т.docx

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Аудитын код: **ДУАГ-САБ/2017/01-ГА**

Аудитын нэр: **“Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын үр дүн”**

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсөн хуулийн заалт	Зөрчлийн дүн сая.төг	Үүнээс				Үр өгөөжийн	
				Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Тоо	Мөнгөн дүн
1	Зээлийн гэрээний дагуу төлөлт хийгдээгүй хугацаа хэтэрсэн авлага барагдуулаагүй нь "Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээ"-ний 2.2-т /Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж дуусгана заасныг зөрчсөн	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, зээлдэгчтэй байгуулсан “Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ”-ний 2.2-т /Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж дуусгана/	25.4		25.4			1	25.4

2	Төсөл хэрэгжүүлэгч А.Цолмонбаатар нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, үндсэн зээл, зээлийн хүүг тогтоосон хугацаанд төлөөгүй, хугацаа хэтрүүлэн Сум хөгжүүлэх санд нийт 30,434,483.00 төгрөгийн хохирол учруулсан	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 6.3-т / Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай этгээд хариуцаж барагдуулна/ зээлдэгчтэй байгуулсан "Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ"-ний 2.2-т /Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж дуусгана/	30.4		30.4			1	30.4
3	22 төсөл хэрэгжүүлэгчдийн үндсэн зээл, зээлийн хүү гэрээний хугацаанд төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулаагүй	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 6.3-т / Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай этгээд хариуцаж барагдуулна/ зээлдэгчтэй байгуулсан "Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ"-ний 2.2-т /Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж дуусгана/	66.7		66.7			1	66.7
4	Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, төслийг зориулалт бусаар зарцуулж, үндсэн зээл, зээлийн хүүг хугацаандаа төлөөгүй	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.5-д /Сангийн хөрөнгө нь сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдана/, 4,7-т / Иргэн хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө/ зээлдэгчтэй байгуулсан "Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ"-ний 2.2-т /Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж дуусгана/	43.4		43.4			1	43.4

5	Төсөл хэрэгжүүлэгчид үндсэн зээл зээлийн хүүг хугацаандаа төлөгдөөгүйгээс 45,627,172.00 төгрөгийн алданги үүсч, гэрээний дагуу бүртгэлд тусгасныг зээлдэгч нар төлөөгүй	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4,7-т / Иргэн хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө/ зээлдэгчтэй байгуулсан “Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ”-ний 2.2-т /Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж дуусгана/, 2.4-т / Энэхүү гэрээний 2.2-т заасан хугацаанд зээлийн эргэн төлөлтийг заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг эсвэл зээл төлөх хугацаа хэтэрсэн бол зээлийн хүүгээс гадна сарын 3 хувийн торгууль төлнө/	45.6		45.6			1	45.6
6	Гэрээний хугацаандаа эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг төлж барагдуулаагүй	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, зээлдэгчтэй байгуулсан “Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ”-ний 3.2-т /Зээлдэгч авсан зээлийн төлбөр болон хүүг энэхүү гэрээний 1.3-т заасан хугацаанд бүрэн эргүүлэн төлөх үүрэг хүлээх буюу хавсралтад тодорхойлсон төлбөрийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ/	28.1		28.1			1	28.1
7	Гэрээний хугацаандаа эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг төлж барагдуулаагүй	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, зээлдэгчтэй байгуулсан “Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ”-ний 3.2-т /Зээлдэгч авсан зээлийн төлбөр болон хүүг энэхүү гэрээний 1.3-т заасан хугацаанд бүрэн эргүүлэн төлөх үүрэг хүлээх буюу хавсралтад тодорхойлсон төлбөрийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ/	75.1		75.1			1	75.1
8	Гэрээний хугацаандаа эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг төлж барагдуулаагүй	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, зээлдэгчтэй байгуулсан “Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ”-ний 3.2-т /Зээлдэгч авсан зээлийн төлбөр болон хүүг энэхүү гэрээний 1.3-т заасан хугацаанд бүрэн эргүүлэн төлөх үүрэг хүлээх буюу хавсралтад тодорхойлсон төлбөрийн хуваарийн	107.7		107.7			1	107.7

		дагуу гүйцэтгэнэ/							
9	Сум хөгжүүлэх сангаас төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 6.3-т / Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу гэм буруутай этгээд хариуцаж барагдуулна/	8.7		8.7			1	8.7
10	Гэрээний хугацаандаа эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг төлж барагдуулаагүй	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, зээлдэгчтэй байгуулсан "Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ"-ний 3.2-т /Зээлдэгч авсан зээлийн төлбөр болон хүүг энэхүү гэрээний 1.3-т заасан хугацаанд бүрэн эргүүлэн төлөх үүрэг хүлээх буюу хавсралтад тодорхойлсон төлбөрийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ/	94.6			94.6		1	94.6
11	2017 оны 05 сарын 31-ны байдлаар харилцах данс 88,357,334.00 төгрөгийн үлдэгдэлтэй. Хүлээгдэж байгаа 11 төслийг сонгон шалгаруулаагүй байна.	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.11-т /сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-иос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухай сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтооно/	88.4				88.4		
12	Сангийн дансны үлдэгдлийг 2017 оны 01- 06 сарын хооронд эргэлтэнд оруулаагүйгээс сангийн хөрөнгө 774,735.00 төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан мөн төсөл	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.11-т /сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-иос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухай сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтооно/	0.7				0.7		

	хэрэгжүүлэгч нарын хүсэл сонирхолыг хязгаарласан байна								
13	2016, 2017 онд алданги тооцож аваагүй, орлого олох боломжийг алдсан	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.7-д /Зээлдэгч зээлээ хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэнхоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчдтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана/	18.0				18.0		
14	Зээлийн хүүгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/	5.6				5.6		
15	2016, 2017 онд алданги тооцож аваагүй, орлого олох боломжийг алдсан	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.7-д /Зээлдэгч зээлээ хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэнхоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчдтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана/	29.8				29.8		
16	Гэрээний хугацаандаа эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг төлж барагдуулаагүй	Иргэний хуулийн 222.4-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна.../, 222.5-д /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй/, зээлдэгчтэй байгуулсан "Сум хөгжүүлэх сангаас зээл олгох гэрээ"-ний 3.2-т /Зээлдэгч авсан зээлийн төлбөр болон хүүг энэхүү гэрээний 1.3-т заасан хугацаанд бүрэн эргүүлэн төлөх үүрэг хүлээх буюу хавсралтад тодорхойлсон төлбөрийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ/	97.1		85.2		11.9	1	85.2
17	Төсөл хэрэгжүүлэгчид үйл ажиллагаагаа эхлээгүй, удаашралтай байна	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3.5.3-т /энэ журмын 3.5.2-т заасан төслийг хэрэгжүүлэх иргэн хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах/	70.0				70.0		

18	Хүчин төгөлдөр бус шийдвэрээр урамшуулал олгосон	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.8-д /сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна/	2.2				2.2		
19	2016, 2017 онд алданги тооцож аваагүй, орлого олох боломжийг алдсан	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.7-д /Зээлдэгч зээлээ хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэнхоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчдтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана/	48.6				48.6		
20	2016, 2017 онд алданги тооцож аваагүй, орлого олох боломжийг алдсан	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан " Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.7-д /Зээлдэгч зээлээ хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэнхоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчдтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана/	38.7				38.7		
Дүн			924.8	-	516.3	94.6	313.9	11	610.9

АУДИТЫН ГАЗАР

Хавсралт-1

Сум хөгжүүлэх сангийн орлогын бүтэц

/мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	2016 он				2017 оны эхний 5 сар				
		Үндсэн зээлээс	Зээлийн хүүгээс	алдангиас	бусад	бүгд	Үндсэн зээлээс	Зээлийн хүүгээс	алданги	бүгд
1	Дэлгэрцогт	67,975.9	5,664.9			73,640.8	23,721.3	1,913.3		25,634.6
2	Дэрэн	55,351.4	3,566.8		462.7	59,380.9	23,275.8	1,315.2		24,591.0
3	Цагаандэлгэр	21,512.2	1,955.5	298.2		23,765.9	15,221.5	1,114.5		16,336.0
4	Говь-Угтаал	40,892.8	1,455.6	1,245.5		43,593.9	32,524.0	577.6		33,101.6
5	Баянжаргалан	37,827.7	3,363.4	-		41,191.1	38,850.0	350.8	-	39,200.8
6	Гурвансайхан	24,762.9	1,901.3	1.3		26,665.5	22,026.9	2,839.7	724.5	25,591.1
7	Өндөршил	23,227.2	1,396.6			24,623.8	4,960.0	182.2		5,142.2
8	Өлзийт	59,046.0	2,464.0			61,510.0	13,518.7	141.6		13,660.3
9	Хулд	47,948.1	2,178.1	104.1		50,230.3	16,419.6	886.6	24.0	17,330.2
10	Луус	65,137.5	4,789.3	-		69,926.8	34,033.5	2,006.0	-	36,071.1
11	Дэлгэрхангай	33,650.6	2,133.3			35,783.9	19,302.6	1,352.2		20,654.8
12	Эрдэнэдалай	86,859.0	3,502.1	13,011.6		103,372.7	26,101.4	1,122.0	238.6	27,462.0
13	Сайхан-Овоо	27,013.1	1,046.4	-		28,059.5	24,435.0	1,998.2		26,433.2
14	Адаацаг	102,645.9	4,121.6	935.6		107,703.1	34,596.1	1,024.7	391.8	36,012.6
15	Сайнцагаан	374,012.9	23,652.9	1,611.0	50.0	399,326.8	151,285.5	8,399.4	6,796.6	166,481.5
	ДҮН	1,067,863.2	63,191.8	17,207.3	512.7	1,148,775.0	480,271.9	25,224.0	8,175.5	513,703.0

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын судалгаа

/мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	2016 он /жилээр/				2017 он /эхний 5 сарын дүнгээр/		
		Сургалтанд	Бусад	хяналтанд	бүгд	Сургалтанд	хяналтанд	бүгд
1	Дэлгэрцогт	698.0	770.0		1,468.0			
2	Дэрэн	900.0	770.0	825.0	2,495.0			
3	Цагаандэлгэр		770.0	315.0	1,085.0			
4	Говь-Угтаал		770.0		770.0	295.5		295.5
5	Баянжаргалан		770.0	34.0	804.0	135.0		135.0
6	Гурвансайхан		770.0		770.0			
7	Өндөршил		770.0	347.5	1,117.5			
8	Өлзийт	155.0	770.0	430.2	1,355.2			
9	Хулд		2,370.0		2,370.0			
10	Луус		770.0	694.5	1,464.5		83.5	83.5
11	Дэлгэрхангай		770.0		770.0			
12	Эрдэнэдалай	1,088.5	4,570.0	254.1	5,912.6	246.5	114.1	360.6
13	Сайхан-Овоо		1,100.0		1,100.0	140.0	328.4	468.4
14	Адаацаг	53.6	770.0	1,386.1	2,209.7	264.0		264.0
15	Сайнцагаан	1,169.1	770.0	134.4	2,073.5	1,414.5		1,414.5
	ДҮН	4,064.2	17,280.0	4,420.8	25,765.0	2,495.5	526.0	3,021.5

Сум хөгжүүлэх сангийн авлагын насжилтын судалгаа

Хавсралт-3

/мянган төгрөгөөр/

Д/д	Сумдын нэр	0-30 хоног	31-60 хоног	61-90 хоног	91-120 хоног	121-150 хоног	151-180 хоног	181-210 хоног	210 -аас дээш хоног	Дүн
1	Дэлгэрцогт	45,552.0							132,494.7	178,046.7
2	Дэрэн	72,835.3	2,192.5			511.3	100.0	7,557.5	52,924.1	136,120.7
3	Цагаандэлгэр	77,799.2	2,700.0			4,612.5	-	7,250.0	42,816.3	135,178.0
4	Говь-Угтаал	29,528.6	2,142.8	902.3	900.5	905.9	865.3	876.9	17,104.2	53,226.5
5	Баянжаргалан	7,000.0				5,000.0	4,646.3		94,490.2	111,136.5
6	Гурвансайхан	4,210.8	496.6	496.5	492.6	490.5	488.9	482.4	155,644.4	162,802.7
7	Өндөршил	19,763.4		51,000.0					91,064.9	161,828.3
8	Өлзийт		16,283.1					3,811.4	98,317.1	118,411.6
9	Сайхан-Овоо	46,464.6	1,026.9					4,120.0	80,296.5	131,908.0
10	Дэлгэрхангай	116,575.6	3,327.0	21,468.1						141,370.7
11	Сайнцагаан	779,170.7	12,305.1	8,679.7	6,770.3	7,187.3	9,069.5	7,484.6	140,346.1	971,013.3
12	Хулд		7,000.0	29,500.0					160,510.3	197,010.3
13	Луус	97,670.6	4,580.2	1,742.1	1,749.0	1,549.0	1,699.0	1,649.0	18,635.1	129,274.0
14	Адаацаг	47,898.6		75,870.0					60,803.0	184,571.6
15	Эрдэнэдалай	90,845.6	986.2	861.1	882.5	802.4	823.5	844.2	149,817.9	245,863.4
	Дүн	1,435,315.0	53,040.4	190,519.8	10,794.9	21,058.9	17,692.5	34,076.0	1,295,264.8	3,057,762.3